

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Алтай орон сууцны корпораци ААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ГАА-2026/007/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: <a href="mailto:gunjidmaag@audit.gov.mn">gunjidmaag@audit.gov.mn</a> Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegd@audit.gov.mn">erdenechimegd@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Д.Цэрэнханд Утас: 99086371 Цахим хаяг: <a href="mailto:tserenkhandd@audit.gov.mn">tserenkhandd@audit.gov.mn</a> Аудитор: Б.Цэвэлмаа Утас: 99026016 Цахим хаяг: <a href="mailto:tsevelmaab@audit.gov.mn">tsevelmaab@audit.gov.mn</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091  
Утас: (976) 70 48 34 13,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026.03.15

№

134

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

АЛТАЙ ОРОН СУУЦНЫ  
КОРПОРАЦИ АЖ АХУЙН ТООЦООТ  
ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
Д.НАРАНЧИМЭГ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Алтай орон сууцны корпорацийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв илэрхийлсэн байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй болно. Үүнд:

- Үл хөдлөх эд хөрөнгө зээлээр худалдан авах гэрээний төлбөр төлөх хуваарьт хугацаанд 37,741.9 мянган төгрөгийн үндсэн төлбөрийг оршин суугчдаар төлүүлээгүй,
- Монгол Улсын Хөгжлийн банканд төлөх, зээлээр худалдан авсан үл хөдлөх эд хөрөнгийн зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүүг төлөх эх үүсвэрийг шийдвэрлээгүйгээс 2025 оны жилийн эцсийн байдлаар орон сууцны үндсэн төлбөр, зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүүгийн төлбөр нийт 6,141,362.4 мянган төгрөгийн төлөгдөөгүй үлдэгдэлтэй нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1, 41.2.7, Төрийн түрээсийн орон сууцанд орон сууц түрээслэх гэрээний 3 дугаар зүйлийн 3.2, Үл хөдлөх хөрөнгө зээлээр худалдах, худалдан авах гэрээний 2 дугаар зүйлийн 2.3 дахь

822511000402

хэсэгтэй нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Зээлээр худалдан авсан үл хөдлөх эд хөрөнгийн зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүүг Монгол Улсын Хөгжлийн банканд төлөх эх үүсвэрийг шийдвэрлээгүйгээс Солонго хорооллын 120 айлын орон сууцны зээл төлсөн үндсэн төлбөрийг зээлийн хүүд суутган тооцсон байна.

Иймд зээлийн үндсэн төлбөрийг бүрэн барагдуулсан 85 иргэний үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээ гараагүй байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Хөгжлийн банк Говь-Алтай аймгийн Засаг дарга нар 2020 оны 08 дугаар сарын 21-ний өдөр 2/68 дугаар “Үл хөдлөх хөрөнгө зээлээр худалдах, худалдан авах гэрээ”-г байгуулсан байна. Тус гэрээнд худалдан авагчийн төлсөн төлбөрийг гэрээний хавсралт 2-т тусгасны дагуу үүссэн хүүгийн төлбөрийн өр, алданги, хүүгийн авлага, үндсэн төлбөр гэсэн дарааллын дагуу суутгахаар заасан байна.

Монгол Улсын Хөгжлийн банканд төлөх, зээлээр худалдан авсан үл хөдлөх эд хөрөнгийн зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүүг төлөх эх үүсвэрийг шийдвэрлээгүйгээс 2025 оны эцсийн байдлаар орон сууцны үндсэн төлбөр, хүү, алдангийн нийт 6,141,362.4 мянган төгрөгийн төлөгдөөгүй үлдэгдэлтэй байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд тус газар нь 5 зорилт, 36 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, аймгийн Засаг даргаас биелэлтийг 96.5 хувиар дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6,181,677,568.44</b>	<b>6,079,376,038.68</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>509,828,670.93</b>	<b>1,296,396,624.80</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>509,828,670.93</b>	<b>1,296,396,624.80</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>509,828,670.93</b>	<b>1,296,396,624.80</b>
31213	Арилжааны банк дахь харилцах	509,828,670.93	1,296,396,624.80
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>5,489,000,237.51</b>	<b>4,598,331,473.88</b>
33401	Дансны авлага /ТӨҮГ/	2,759,307,012.00	1,867,000,107.29
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	4,749,366.68	58,337.75
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>2,724,943,858.83</b>	<b>2,731,273,028.84</b>
33510	Байгууллагаас авах авлага	2,724,943,858.83	2,728,633,028.84
33520	Хувь хүмүүсээс авах авлага	0.00	2,640,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>2,848,660.00</b>	<b>4,647,940.00</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>2,848,660.00</b>	<b>4,647,940.00</b>
35420	Аж ахуйн материал	2,848,660.00	4,647,940.00
<b>360</b>	<b>БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>	<b>180,000,000.00</b>	<b>180,000,000.00</b>
36900	БЗЭБүй эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	180,000,000.00	180,000,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>265,149,054.00</b>	<b>708,945,128.00</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>265,149,054.00</b>	<b>708,945,128.00</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>14,576,054.00</b>	<b>11,837,128.00</b>
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	7,373,940.00	6,527,910.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(2,892,451.00)	(3,489,452.00)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,249,390.00	12,388,190.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(3,154,825.00)	(3,589,520.00)
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>250,573,000.00</b>	<b>697,108,000.00</b>
39301	Програм хангамж	2,730,000.00	2,730,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(637,000.00)	(872,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	248,480,000.00	695,250,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>6,446,826,622.44</b>	<b>6,788,321,166.68</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>5,789,615,168.50</b>	<b>5,698,923,593.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>181,060,402.50</b>	<b>89,805,191.00</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>1,776,770.82</b>	<b>0.00</b>
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>1,776,770.82</b>	<b>0.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	1,594,771.00	0.00
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	181,999.82	0.00
<b>41400</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	<b>179,283,631.68</b>	<b>89,805,191.00</b>
41420	Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	162,416,682.00	89,805,191.00
41440	Бусад урьдчилж орсон орлого	16,866,949.68	0.00
<b>42</b>	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>5,608,554,766.00</b>	<b>5,609,118,402.00</b>
<b>42200</b>	<b>Урт хугацаат зээл</b>	<b>5,608,554,766.00</b>	<b>5,609,118,402.00</b>
<b>42210</b>	<b>Төгрөг</b>	<b>5,608,554,766.00</b>	<b>5,609,118,402.00</b>
42243	Санхүүгийн бусад байгууллага /ТӨҮГ/	5,608,554,766.00	5,609,118,402.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>657,211,453.94</b>	<b>1,089,397,573.68</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>657,211,453.94</b>	<b>1,089,397,573.68</b>
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>657,211,453.94</b>	<b>1,089,397,573.68</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	432,915,598.48	657,211,453.94
51220	Тайлант үеийн үр дүн	224,295,855.46	432,186,119.74
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>6,446,826,622.44</b>	<b>6,788,321,166.68</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>418,012,150.00</b>	<b>637,661,712.33</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>418,012,150.00</b>	<b>637,661,712.33</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>418,012,150.00</b>	<b>637,661,712.33</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>46,514,421.00</b>	<b>71,664,498.33</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	46,514,421.00	71,664,498.33
120005	Түрээсийн орлого	84,543,994.00	60,466,937.00
120009	Бусад орлого	55,666,900.00	58,760,277.00
120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	39,046,835.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	192,240,000.00	446,770,000.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>193,716,294.54</b>	<b>205,475,592.59</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>193,716,294.54</b>	<b>205,475,592.59</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>193,716,294.54</b>	<b>205,475,592.59</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>193,716,294.54</b>	<b>205,475,592.59</b>
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	193,716,294.54	205,475,592.59
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>224,295,855.46</b>	<b>432,186,119.74</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>224,295,855.46</b>	<b>432,186,119.74</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,297,216,833.31</b>	<b>955,973,986.49</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,297,216,833.31</b>	<b>955,973,986.49</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,297,216,833.31</b>	<b>955,973,986.49</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>1,165,148,047.31</b>	<b>850,110,533.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,165,148,047.31	850,110,533.00
120005	Түрээсийн орлого	76,401,886.00	51,709,988.00
120009	Бусад орлого	55,666,900.00	54,153,465.49
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>183,263,395.29</b>	<b>240,520,342.46</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>183,263,395.29</b>	<b>240,520,342.46</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>183,263,395.29</b>	<b>240,520,342.46</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>114,925,544.00</b>	<b>117,060,595.00</b>
210106	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	114,925,544.00	117,060,595.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>25,584,448.00</b>	<b>27,065,774.21</b>
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	25,584,448.00	27,065,774.21
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>8,787,607.50</b>	<b>6,131,918.77</b>
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	8,787,607.50	6,131,918.77
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>6,021,850.00</b>	<b>10,861,896.00</b>
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/	1,448,900.00	289,296.00

210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	4,572,950.00	10,572,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>27,943,945.79</b>	<b>79,400,158.48</b>
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	22,119,973.68	20,795,805.17
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	5,823,972.11	58,604,353.31
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>1,113,953,438.02</b>	<b>715,453,644.03</b>
<b>IV</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	<b>46,514,421.00</b>	<b>71,499,309.84</b>
140007	Хүлээн авсан хүүний орлого	46,514,421.00	71,499,309.84
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>1,005,686,000.00</b>	<b>385,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,005,686,000.00</b>	<b>385,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>1,005,686,000.00</b>	<b>385,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	150,000.00	385,000.00
225105	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа /ТӨҮГ/	1,005,536,000.00	0.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(959,171,579.00)</b>	<b>71,114,309.84</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>154,781,859.02</b>	<b>786,567,953.87</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	355,046,811.91	509,828,670.93
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	509,828,670.93	1,296,396,624.80

#### 2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	432,915,598.48	432,915,598.48
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	432,915,598.48	432,915,598.48
9	Тайлант үеийн үр дүн	224,295,855.46	224,295,855.46
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	657,211,453.94	657,211,453.94
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	657,211,453.94	657,211,453.94
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	657,211,453.94	657,211,453.94
19	Тайлант үеийн үр дүн	432,186,119.74	432,186,119.74
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,089,397,573.68	1,089,397,573.68

#### 2.5 Аудит хийсэн эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Үзүүлэлт	Тайлант оны	Хувь
----------	-------------	------

	<b>Батлагдсан төлөвлөгөө</b>	<b>Гүйцэтгэл</b>	<b>Төсвийн хэмнэлт+, хэмнэлт-</b>	
Техник хяналтын орлого	38,500,000.00	21,400,000.00	17,100,000.00	56
Түрээсийн орлого /Граж	15,300,000.00	14,010,000.00	1,290,000.00	92
Түрээсийн орлого /орон сууц	47,098,000.00	46,456,937.00	641,063.00	99
Хадгаламжийн болон харилцах дансны хүүгийн орлого		71,664,498.33	(71,664,498.33)	100
Сууц эзэмшигчийн үйлчилгээний хураамж	97,500,000.00	28,170,000.00	69,330,000.00	29
Бусад орлого	10,020,000.00	9,190,277.00	829,723.00	92
<b>ОРЛОГО</b>	<b>208,418,000.00</b>	<b>190,891,712.33</b>	<b>17,526,287.67</b>	<b>92</b>
<b>Нийт орлого</b>	<b>208,418,000.00</b>	<b>190,891,712.33</b>	<b>17,526,287.67</b>	<b>92</b>
Үндсэн үйл ажиллагааны зардал	208,033,300.00	201,372,597.46	6,660,702.54	97
<b>Үйл ажиллагааны зардлын дүн</b>	<b>208,033,300.00</b>	<b>201,372,597.46</b>	<b>6,660,702.54</b>	<b>97</b>
<b>1.5 Үндсэн үйл ажиллагааны ашиг /алдагдал/</b>	<b>384,700.00</b>	<b>(10,480,885.13)</b>	<b>10,865,585.13</b>	
<b>3. Татвар төлөхийн өмнөх ашиг алдагдал</b>	<b>384,700.00</b>	<b>(10,480,885.13)</b>	<b>10,865,585.13</b>	
<b>4. Татварын дараах ашиг алдагдал</b>	<b>384,700.00</b>	<b>(10,480,885.13)</b>	<b>10,865,585.13</b>	
<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>			-	-
<b>АЖИЛЛАГААНЫ ТОО</b>	7.00	7.00	-	-
Удирдах ажилтан	1.00	1.00	-	-
Гүйцэтгэх ажилтан	3.00	3.00	-	-
Үйлчлэх ажилтан	3.00	3.00	-	-

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

#### 3.1 Залруулсан алдаа

Аудитаар 393,811.5 мянган төгрөгийн бүртгэл тайлагнал, мэдээллийг тусгахгүй орхигдуулсан алдаа<sup>1</sup>-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

**Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:**

- Санхүүгийн байдлын тайланд авлагыг 9,045.8 мянган төгрөгөөр, өглөгийг 6,593.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.
- Мөнгөн гүйлгээний тайланд үндсэн үйл ажиллагааны орлогыг 202,940.9 мянган төгрөгөөр, хадгаламжийн хүүгийн орлогыг 19,334.1 мянган төгрөгөөр дутуу, зардлыг 60,773.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.
- Ажилчдын цалинг хувь хүний орлогын албан татварын тайланд 6,239.3 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.

**Мэдээллийг тусгахгүй орхигдуулсантай холбоотой:**

- Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 184,631.3 мянган төгрөгийн 19 орлогын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/, ГАА-2026/007/НА-СТА-ОНӨҮГ

Залруулагдаагүй нийт 37,741.9 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 37,741.9 мянган төгрөгийн 2 зөрчил<sup>2</sup> илэрсэнд 37,741.9 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1 зөрчлийг арилгах зөвлөмж хүргүүллээ.

### **3.2 Төлбөрийн акт**

Нэг. Орон сууц түрээслэх гэрээнд заасан хуваарьт хугацаанд 37,741.9 мянган төгрөгийн үндсэн төлбөрийг түрээслүүлэгчээр төлүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Төрийн түрээсийн орон сууцанд орон сууц түрээслэх гэрээний 3.2-т "Гэрээний хавсралтад заасан төлбөр төлөлтийн хуваарийн дагуу төлбөрийг 2 сар төлөөгүй тохиолдолд сануулах ба 3 сараас дээш хугацаагаар төлөөгүй тохиолдолд түрээслээд өмчлөгчтэй байгуулсан гэрээг цуцалж энгийн түрээсээр тооцож хуримтлуулсан урьдчилгаанаас тооцож авна" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээнд заасан хуваарьт хугацаанд төлөгдөөгүй үндсэн төлбөрийг төлүүлж харилцах дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

### **3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **Нэг. Төсвийн зарцуулалттай холбоотой**

1. Илрүүлэлт: Монгол Улсын Хөгжлийн банканд төлөх, зээлээр худалдан авсан үл хөдлөх эд хөрөнгийн зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүүг төлөх эх үүсвэрийг шийдвэрлээгүйгээс 2025 оны эцсийн байдлаар орон сууцны үндсэн төлбөр, зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүүгийн төлбөрт нийт 6,141,362.4 мянган төгрөгийн төлөгдөөгүй үлдэгдэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7-т "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Үл хөдлөх эд хөрөнгө зээлээр худалдах, худалдан авах гэрээний 2.3-т "Худалдан авагч зээлээр худалдан авсан үл хөдлөх хөрөнгийн үнийг Гэрээний Хавсралт 2-т тусгасан хуваарийн дагуу төлөөгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн дүнгийн 0.3 хувиар тооцож, алданги ногдуулна" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Монгол Улсын Хөгжлийн банканд төлөх хугацаа хэтэрсэн зээлийг шийдвэрлэх арга хэмжээ авах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2027 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

## 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл (мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Говь-Алтай аймгийн Алтай орон сууцны корпораци ААТҮГ	Мөнгөн гүйлгээний тайланд үндсэн үйл ажиллагааны орлогыг 107,194.9 мянган төгрөгөөр, хадгаламжийн хүүгийн орлогыг 19,334.1 мянган төгрөгөөр дутуу, зардлыг 60,773.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.	1	187,302.0	-	-	1	187,302.0	1	187,302.0	-	-	-	-
	Санхүүгийн байдлын тайланд авлагыг 9,045.8 мянган төгрөгөөр, өглөгийг 6,593.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	15,638.9			1	15,638.9	1	15,638.9	-	-	-	-
	Ажилчдын цалинг хувь хүний орлогын албан татварын тайланд 6,239.3 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.	1	6,239.3			1	6,239.3	1	6,239.3				
	Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 184,631.3 мянган төгрөгийн 19 орлогын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй.	1	190,613.3	1	190,613.3	-	-	1	190,613.3	-	-	-	-
<b>Дүн</b>		<b>4</b>	<b>399,811.5</b>	<b>1</b>	<b>190,613.3</b>	<b>3</b>	<b>209,180.2</b>	<b>4</b>	<b>399,811.5</b>	-	-	-	-

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл /мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Говь-Алтай аймгийн Алтай орон сууцны корпораци ААТҮГ	Гэрээнд заасан хуваарьт хугацаанд 37,741.9 мянган төгрөгийн үндсэн төлбөрийг төлүүлээгүй.	1	37,741.9	1	37,741.9	-	-	-	-	-	-
	Монгол Улсын Хөгжлийн банканд төлөх, зээлээр худалдан авсан үл хөдлөх эд хөрөнгийн зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүүг төлөх эх үүсвэрийг шийдвэрлээгүйгээс 2025 оны эцсийн байдлаар орон сууцны үндсэн төлбөр, зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүүгийн төлбөрт нийт 6,141,362.4 мянган төгрөгийн төлөгдөөгүй үлдэгдэлтэй байна.	1	-	-	-	-	-	-	1	-	-
<b>Дүн</b>		<b>2</b>	<b>37,741.9</b>	<b>1</b>	<b>37,741.9</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>		<b>-</b>